



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А186

Чойр


Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.13, Согтууруулах ундааны эрэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15<sup>1</sup> дүгээр зүйлийн 15<sup>1</sup>.4, 40 дүгээр зүйлийн 40.9, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүмбэр сумын Найрамдал багт байрлах "Гэээгт Нөхөрлөл" ЗБН-ийн супермаркетад сул болон өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 2029 оны 02 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай.

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдэд тавигдах нөхцөл шаардлагыг бүрэн хангаж ажиллахыг "Гэээгт Нөхөрлөл" ЗБН-ийн захирал Ч.Болормаад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Нэргүйцэцэг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Хонгор), Цагдаагийн хэлтсийн дарга (хурандаа Ц.Баярхүү), Эрүүл мэндийн газрын дарга (Ц.Мөнх-Од), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Э.Түвшинзаяа), Татварын хэлтсийн дарга (П.Энх-Оюун), Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Байгальсайхан), Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Жамбаасүрэн) нарт тус тус даалгасугай.



4212400179